



Фоксконн олон үндэстнээ танилцуулж байна



Болгар улс

Болгар үндэстний Мусака, Баница хоолыг амтлаарай!

Мусака

Орц:

Татсан мэх 1kg.
Төмс 1/2kg.
Сонгино 1 ш
Лууван 2 ш
Дарсан улаан
лооль 1 лээз
Яншуй
Хар перец
Давс
Ургамлын тос
Хольц хийхэд 200гр-д 2 өндөг.
Тараг, Давс, Перец



Жор: Төмс луувангаа хальсалж угаагаад жижиг дөрвөлжин хэрчинэ. Сонгино жижиглэж хэрчинэ. Татсан мэх, төмс, лууван, сонгино, лоолийн нөөшийг бүгдийг хольж бусад амтлагчаар амтлана. Холимогоо саванд хийгээд шарах шүүгээнд жигнэнэ. Тавганд өндгөө хутгаад дээр нь тараг, давс, перец нэмж амтлан хутгана. Холимгийг шарах шүүгээнээс гаргаад дээр нь тарагтай хольцоо жигд асгаад ахин шарах шүүгээнд жигнэнэ.

Баница (давстай жигнэмэг)

Орц:

Давхраат зуурмаг
(болгарын)
Өндөг 6
Балкан бяслэг 400гр
Цагаан тараг 400гр
Хийжүүлсэн ус 250гр
Сода 1 цайны халбага
Давс
Ургамлын тос



Жор: Хагалсан өндгөө саванд хийж дээр нь тараг, сода, ургамлын тос, хийжүүлсэн ус, жижиглэсэн бяслэг нэмээд хутгана. Шарах саваа тослоно. Давхраат зуурмагийг саванд хийж хавтгайлж тараагаад дээр нь холимогоо хийж жигд тараана. Шарах шүүгээнд жигнэнэ.

Сайхан хооллоорой!



FOXCONN